

Та мэдэх үү?

Тэмбүү хэнийг ч ялгахгүй халдварладаг ноцтой халдвар юм.



Шинжилгээ өгч, эмчилгээ хийлгээд бүрэн эдгээрэй!

Эмчилгээ хийлгэхгүй бол тэмбүү таны эрүүл мэндэд ноцтой хүндрэл үүсгэж болзошгүй.



Танд ямар ч шинж тэмдэг илрэхгүй байж болно

Тэмбүү (БЗДХ-ын нэг төрөл)-гээр хэн ч өвдөж болно.

Та халдвар авснаа мэдэлгүй явж байж болно. Өөрийгөө болон бусдыг хамгаалахын тулд тогтмол шинжилгээ өгч хэвшээрэй.



Шинжилгээ өгч, эмчилгээ хийлгээд бүрэн эдгээрэй!

Тэмбүүг эмчлэх хялбар.

Танд шинж тэмдэг илрээгүй байсан ч гэсэн эмч болон эрүүл мэндийн төвд хандан, тэмбүүгийн сорилыг агуулсан БЗДХ-ын бүрэн шинжилгээнд хамрагдаарай.



Жирэмсэн үеийн хяналт

Та жирэмсэн юмуу жирэмслэхээр төлөвлөж байгаа бол аль болох эрт шинжилгээнд хамрагдах нь урагт халдвар дамжихаас сэргийлэхэд нэн чухал.



Урьдчилан сэргийлэх

Тэмбүүгээс сэргийлэх хамгийн оновчтой арга бол аюулгүй бэлгийн харилцааг эрхэмлэх юм - үргэлж бэлгэвч хэрэглэх ба чийгшүүлэгч/лубрикант ашиглахдаа усан болон силикон суурьтайг сонгон хэрэглэх.

Халдварыг бусдад болон танд буцаан халдаахаас сэргийлэхийн тулд бэлгийн хамтрагч тань мөн адил тогтмол шинжилгээ өгөх хэрэгтэй.



Мэргэшсэн сувилагчтай ярихыг хүсвэл

1800 451 624 дугаараар Sexual Health Info Line (SHIL) (Бэлгийн Эрүүл Мэндийн Мэдээллийн Шугам). Даваа – Баасан 09:00 - 5:30 цагийн хооронд.

131 450 руу залгаж орчуулагчтай холбогдон, төрөлх хэлээрээ яриарай.

Жилийн бүх өдрүүдэд, 24 цагийн турш нээлттэй.

www.shil.nsw.gov.au вэбсайтаар зочлоорой



QR кодыг уншуулж тэмбүүгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.